



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 12 дөр

Дугаар 687

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны 467 дугаар тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 5 нэрийн, нийт 406,849,935.36 (дөрвөн зуун зургаан сая найман зуун дөчин есөн мянга есөн зуун гучин таван төгрөг гучин зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Б.Чагнаадорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу байгууллагын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.4. Арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

130002752

29-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 18-дугаар сарын 12-ны өдрийн
68.7 дугаар тогтоолын хавсралт

"ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашин ы нэр, улсын болон хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Сэргээн босголтын зардал	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Чирэгч толгой SHAAXI SX4324, 2106 ДАР	2007	144,129,840.29	144,129,840.29	-	-	13,000,000.00
2	Хагас ачааны HONDA RIDGELINE, 6137 ДАХ	2008	29,900,000.00	29,900,000.00	-	-	6,000,000.00
3	Автогрейдер GR215, 9044 ДА	2009	156,047,367.80	156,047,367.80	-	-	4,000,000.00
4	Ачааны 4тн HINO RANGER, 9997 ДАР	2011	27,272,727.27	27,272,727.27	-	-	10,000,000.00
5	HYUNDAI STAREX, 6999 ДАХ	2013	49,500,000.00	49,500,000.00	-	-	3,000,000.00
	НИЙТ ДҮН		406,849,935.36 (дөрвөн зуун зургаан сая найман зуун дөчин есөн мянга есөн зуун гучин таван төгрөг гучин мөнгө)	406,849,935.36 (дөрвөн зуун зургаан сая найман зуун дөчин есөн мянга есөн зуун гучин таван төгрөг гучин зургаан мөнгө)	-	-	36,000,000.00 (гучин зургаан сая)